



БИОКОМБИНАТ ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.БАТТОГОХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.12 № ҮАГ/САГ/2013/40/СТГА-ТВЧГ 01/12

Өглөг барагдуулах тухай

Биокомбинат ТӨААТҮГазрын 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус байгууллага нь татварын байгууллагад 2012 оны жилийн эцсийн байдлаар 133.8 сая төгрөг НӨАТ-ын өглөг, 20.8 сая төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг улсын төсөвт төлөөгүй байна.

Биокомбинат ТӨААТҮГазар нь албан татварын тайлангаа хуулийн хугацаанд гаргасан боловч НӨАТ-ын хуулийн 16 дугаар зүйл, 16.1, 16.1.1 дэхь заалт, ХХОАТ-ын тухай хуулийн 26,27 дугаар зүйлийн дагуу холбогдох татвараа хугацаандаа төлөөгүй байгаа нь тухайн хуулиудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна. Үүнд:

1. НӨАТ-ын өглөг 133.8 сая төгрөгийн үлдэгдлийг 2013 оны 03 дугаар сарын 31-ний дотор барагдуулах
2. ХХОАТ-ын өглөг 20.8 сая төгрөгийн үлдэгдлийг 2013 оны 03 дугаар сарын 31-ний дотор барагдуулах
3. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Үндэсний аудитын газарт 2013 оны 7 дугаар сарын 1-ний дотор хариу ирүүлэхийг Биокомбинат ТӨААТҮГ-ын захирал Б.Баттогтох, ерөнхий нягтлан бодогч О.Цэндсүрэн нарт хариуцуулав.

АУДИТОР

Р.ЦОЛМОН



070033